



ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ХУДАЛДАН АВАХ
АЖИЛЛАГААНЫ ГАЗАР**

Б корпус, Засгийн газрын IX байр,
Энхтайваны өргөн чөлөө 16, Баянзүрх дүүрэг,
Улаанбаатар хот, 13381
Утас/Факс: (976-51) 26 00 62
Цахим шуудан: info@spa.gov.mn
Цахим хуудас: www.spa.gov.mn

2024.01.19 № А-1/122

танай _____-ны № _____-Т

Тодруулга хүргүүлэх тухай

Тус газраас 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдөр зарласан МОХИУАӨДЗЧНЭМСНТ/202301002 дугаартай "6 сав газрын менежментийн төлөвлөгөөг уур амьсгалын өөрчлөлт, эрсдэл, эмзэг байдалтай уялдуулан шинэчлэх /шинэчлэн боловсруулж батлуулах" төсөл, арга хэмжээний тендер шалгаруулалтад оролцохыг сонирхогч этгээдээс ирүүлсэн тодруулгад дараах хариуг хүргүүлж байна.

Тодруулга	Хариулт
100 саяаас доош үнийн дүнтэй зөвлөх үйлчилгээнд тендерийн баталгаа байршуулж байгаа үндэслэл?	2005 оны 12 дугаар сарын 01-ний өдөр баталсан Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.1 дэх заалтад захиалагч тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох гэж заасны дагуу тендерийн баталгааг шаардсан.
Малзүйч мэргэжлийг сүүлийн жилүүдэд зоо-инженер, технологи мэргэжлээр төгсгөж байна. Иймд зоо инженер, технологи мэргэжилтэй мэргэжилтэнг зөвшөөрөх үү?	Зөвшөөрнө.
Социологич мэргэжилтэнд Түүх, Нийгэм ухааны багш мэргэжилтэй хүнийг зөвшөөрөх үү?	Боловсрол, шинжлэх ухааны яамны баталсан одоо мөрдөгдөж буй мэргэжлийн индекст социологич нь 03140201, Түүх, Нийгмийн ухааны багшийн мэргэжлийн индекс нь 01140301, 01140302 байгаа учир зөвшөөрөхгүй.
Гадаад сургууль төгссөн хүнийг И монголиад бүртгэхэд удаашралтай байгаа учир нотариатаар батлуулсан байдлаар дипломыг хавсаргаж болох уу?	Тендерийн баримт бичгийн ТӨЗ-ны 4.4.4-д Гадаадад мэргэжил эзэмшсэн дипломтой болон техникчийн мэргэжлийн үнэмлэхтэй мэргэжилтнүүд диплом, мэргэжлийн үнэмлэхний хуулбарыг тендерт хавсарган ирүүлнэ гэж заасан.
Усны инженер Усны барилга байгууламжийн инженерийг зөвшөөрөх үү?	Ажлын даалгаварт заасан гидрологи, гидрогеологи, гидротехникийн инженерийн мэргэжлийн индекс нь 0532, Усны барилга байгууламжийн инженерийн мэргэжлийн индекс нь 0732 байгаа тул зөвшөөрөхгүй.

ДАРГА



Ц.БАТЗУЛ

1324020393